

## Article

**Results of the study examining the correlation between students' empathy and stress**

Pagmadulam Sarantuya<sup>1,2\*</sup>, Batchuluun Purev<sup>2</sup>, Enkhbayar Batsaikhan<sup>3</sup>, Bayarmaa Dolgorsuren<sup>4</sup>

<sup>1,4</sup> Graduate School of Education, Graduate University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

<sup>2</sup> School of Medicine, Department of Medicine, Etugen University, Ulaanbaatar, Mongolia

<sup>3</sup> School of Humanities, Department of Psychology and Social Work, Otgontenger University, Ulaanbaatar, Mongolia

\*Corresponding author: [pagma1205@gmail.com](mailto:pagma1205@gmail.com)

 <https://orcid.org/0009-0002-5879-6964>

Received: 01 November 2025

Accepted: 12 December 2025

Published online: 31 December 2025

**Abstract**

**Introduction:** In the 21st century, the rapid development of artificial intelligence, electronic communication, automation, and the digital environment has transformed human social and psychological relationships. This transformation has also raised concerns about a potential decline in empathy—the ability to understand and share the feelings of others—as reported by numerous studies. Empathy has been widely studied across various fields, including education, health, social sciences, humanities, and psychology, and is recognized as an essential skill for maintaining psychological well-being, upholding professional ethics, and facilitating effective communication. As the capacity to understand, experience, and share others' emotions, empathy positively influences clinical skills and professional relationships. Recent research has confirmed the effectiveness of various instructional methods for enhancing empathy, such as the use of art, humanistic approaches, ethics, cultural learning, and clinical communication training. Therefore, the aim of this study was to assess the level of empathy among students at the School of Health Sciences, Etugen University, and to examine its relationship with stress. **Results:** Among 761 students from Etugen University's School of Health Sciences, the mean empathy score was  $21.98 \pm 0.16$ , and the mean emotion regulation score was  $14.8 \pm 0.11$ . A total of 60.71% of participants experienced stress, and higher stress levels were associated with lower empathy scores. Differences across age, gender, and academic year were minimal; however, stress level had a significant negative impact on empathy. **Conclusion:** Empathy plays a crucial role in students' psychological health and professional ethics. As stress levels increase, empathy tends to decrease. Therefore, it is essential to implement empathy development training and stress reduction interventions within educational environments.

**Keywords:** Ethics, communication, emotion, humanistic



© 2025, Author(s). CC BY-NC 4.0. This license enables reusers to distribute, remix, adapt, and build upon the material in any medium or format for noncommercial purposes only, and only so long as attribution is given to the creator.

<https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

## Оюутны эмпати чадварыг стресстэй холбон судалсан дүн

Сарантуяагийн Пагмадулам<sup>1,2</sup>, Пүрэвийн Батчулуун<sup>2</sup>, Батсайханы Энхбаяр<sup>3</sup>, Долгосүрэнгийн Баярмаа<sup>4</sup>

<sup>1,4</sup>Монгол улсын эрдмийн их сургууль, Боловсролын эрдмийн сургууль, Улаанбаатар хот, Монгол улс

<sup>2</sup>Этүгэн их сургууль, Анагаах ухааны тэнхим, Улаанбаатар хот, Монгол улс

<sup>3</sup>Отгонтэнгэр их сургууль, Хүмүүнлэгийн сургууль, Улаанбаатар хот, Монгол улс

### Хураангуй

Үндэслэл: 21-р зууны технологийн эрин үед хиймэл оюун ухаан, цахим харилцаа, автоматжуулалт, дижитал орчны хурдтай хөгжил нь хүний нийгэм сэтгэлзүйн харилцаанд өөрчлөлт оруулж, эмпати буюу бусдыг ойлгох, мэдрэх чадварыг сулруулах эрсдэлтэй болсныг олон судалгаа дээр дурджээ. Эмпати нь боловсрол, эрүүл мэнд, нийгэм, хүмүүнлэг, сэтгэл судлалын салбарт өргөн судлагдаж, хүний сэтгэлзүйн тэнцвэр, мэргэжлийн ёс зүй, харилцааны чухал чадвар болохыг онцолсон байв. Эмпати нь бусдыг ойлгох, мэдрэх, сэтгэлийн хөдөлгөөнийг хуваалцах чадвар бөгөөд эмнэлзүйн ур чадвар, мэргэжлийн харилцаанд эерэг нөлөөтэй байна. Сүүлийн жилүүдэд эмпати хөгжүүлэх сургалтын арга зүй (урлаг, хүмүүнлэг хандлага, ёс зүй, соёлын хичээл, эмнэлзүйн харилцааны сургалт) нэмэгдэж, үр дүнтэй болохыг олон судалгаагаар баталсан байсан учир **Этүгэн их сургуулийн харьяа Эрүүл мэндийн сургуулийн оюутнуудын эмпати чадварын түвшинг тодорхойлж, түүнийг стресстэй холбон судлах** зорилго дэвшүүлсэн. Судалгааны үр дүн: Этүгэн их сургуулийн эрүүл мэндийн чиглэлийн 761 оюутны дунд хийсэн судалгаагаар эмпати чадварын дундаж оноо  $21.98 \pm 0.16$ , сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадварын дундаж оноо  $14.8 \pm 0.11$  байв. Судалгаанд оролцогчдын 60.71% нь стрессийн түвшинтэй байсан бөгөөд стресс нэмэгдэх тусам эмпати чадвар буурах хандлагатай байна. Нас, хүйс, дамжаагаар ялгаа бага, харин стрессийн түвшин эмпати чадварт хүчтэй нөлөөлж байгааг тогтоолоо. Дүгнэлт: Эмпати нь оюутнуудын сэтгэлзүйн эрүүл мэнд, мэргэжлийн ёс зүйд чухал нөлөөтэй бөгөөд стрессийн түвшин нэмэгдэхэд эмпати буурдаг. Иймд эмпати хөгжүүлэх сургалт, стрессийг бууруулах арга хэмжээг боловсролын орчинд түлхүү хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

**Түлхүүр үг:** Хүмүүнлэг хандлага, ёс зүй, харилцаа, сэтгэлийн хөдөлгөөн

### Оршил

XXI зууны дэвшилтэт технологийн эрин үед хиймэл оюун ухаан, цахим харилцаа, автоматжуулалт, дижитал орчны хурдацтай хөгжил нь хүний нийгмийн харилцааны хэлбэрийг эрс өөрчилж байна. Энэхүү технологийн хувьсал нь мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, боловсрол, эрүүл мэндийн салбарт шинэ боломжийг нээж байгаа хэдий ч, нөгөө талаар хүмүүсийн хоорондын сэтгэлзүйн харилцаа, бусдыг ойлгох, мэдрэх эмпати чадварыг сулруулах эрсдэл дагуулж буйг судлаачид анхааруулж байна (Howick et al., 2023). Орчин үеийн оюутнуудын дунд цахим хэрэглээ давамгайлж, нүүр тулсан харилцаа багасах нь эмпати хөгжих орчныг хязгаарлаж, нийгмийн сэтгэлзүйн эрүүл мэндэд нөлөөлж байна. Эмпати нь нийгмийн сэтгэл судлал, боловсрол болон анагаах ухаанд өргөн судлагдаж буй чадамжийн нэг бөгөөд хүний бусдыг ойлгох, мэдрэх, сэтгэл хөдлөлийг хуваалцах чадварыг илэрхийлдэг (Kampourelli, 2022). Олон улсын судалгаагаар эмпати нь хүний сэтгэлзүйн тэнцвэр, мэргэжлийн харилцаа, ёс зүйтэй үйл ажиллагааны үндэс болохыг онцолжээ (Gilligan et al.,

2021; Tement et al., 2021). Гэвч эрүүл мэндийн болон боловсролын чиглэлийн оюутнуудын эмпати түвшин сургалтын жил нэмэгдэх тусам буурах хандлагатай байгааг Ховик болон хамтран судлаачид (Howick et al., 2023) системчилсэн дүн шинжилгээндээ дурдсан байна. Энэ үзэгдлийг “эмпати элэгдэл” хэмээн нэрлэх болсон ба хэт их ачаалал, сэтгэлзүйн дарамт, өрсөлдөөн, цахим сургалтын орчны нөлөөтэй холбоотой гэж үздэг (Cairns et al., 2024). Боловсролын орчинд эмпати хөгжүүлэх янз бүрийн арга зүйг турших оролдлогууд нэмэгдэж байна. Жишээлбэл, mindfulness буюу сэтгэл төвлөрүүлэх сургалт, урлагийн болон хүмүүнлэг, соёлын хичээл, эмнэлзүйн харилцааны сургалт зэрэг нь эмпати түвшинд эерэг нөлөө үзүүлж буйг олон судалгаагаар баталжээ (Chmielewski et al., 2021; Levett-Jones et al., 2024; Zhang et al., 2023). Бошра болон хамтран судлаачид (Boshra et al., 2022) оюутнуудад өвчтөнүүдийн түүхийг сонсуулах, оролцоонд суурилсан сургалтаар эмпати хөгжих боломжтойг илрүүлсэн бол Менезес нар (Menezes et al., 2021) эмпати, энэрэл, хүн төвтэй сэтгэлзүй нь боловсролын орчны зайлшгүй хэсэг байх ёстой гэж дүгнэсэн байна.

Монголын боловсролын орчинд эмпати чадварыг судалсан судалгаа ховор боловч, Энхзул ба Эрдэнэцэцэг (2023) нар сувилахуйн оюутнуудын эмпати чадварын түвшинг судлахад дунд түвшинд байгааг, Баатарсүрэн нар (Baatarsuren et al., 2024) эмпати үнэлэх асуулгын психометрик чанарыг судлан үндэсний хэмжээнд хэрэглэх боломжтойг онцолжээ. Эдгээр үр дүн нь Монголын оюутнуудын эмпати хөгжүүлэх шаардлагыг тодорхой харуулж байна.

Иймээс энэхүү судалгаагаар оюутнуудын эмпати чадварын түвшин, түүний нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох нь нийгмийн сэтгэлзүйн боловсрол, харилцааны соёл, мэргэжлийн ёс зүйн хөгжилд чухал ач холбогдолтой юм. Судалгааны дүн нь цаашид дээд боловсролын хөтөлбөрт эмпати хөгжүүлэх сургалтын агуулга, арга зүйг төлөвшүүлэхэд онолын ба практик үндэслэл болох юм. Энэхүү судалгааны гол зорилго нь **Этүгэн их сургуулийн харьяа Эрүүл мэндийн сургуулийн оюутнуудын эмпати чадварын түвшинг тодорхойлж, түүнийг стресстэй холбон судлах** явдал юм. Зорилгоо амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэв.

1. Судлагдсан байдлын судалгааг тоймлон судлах
2. Оюутаны эмпатигийн түвшнийг тодорхойлж, түүнд нөлөөлж болох **нас, хүйс, суралцаж буй чиглэл, сургалтын жил, стрессийн түвшин** зэрэг хувьсах хүчин зүйлсийг таамаглал дэвшүүлэн шалгах

### **Судалгааны арга зүй**

Ажиглалтын судалгааны нэг агшны загвараар 2021 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн ёс зүйн зөвшөөрлийн дагуу судалгаанд оролцогчдод таниулсан зөвшөөрлийн хуудас өгч танилцуулан зөвшөөрсний үндэс дээр судалгааны материалыг 2022-2023 оны хичээлийн жилд цуглуулсан. Судалгаанд Этүгэн их сургуулийн харьяа Эрүүл мэндийн сургуулийн дөрвөн мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж буй 3200 оюутнаас энгийн санамсаргүй түүврийн аргаар 761 оюутан хамруулсан. Судалгааг тоон судалгааны аргыг ашиглан ерөнхий 4 асуумж, эмпацийг Д.В.Люсины боловсруулсан “ЭМИн” загвар (Люсин Д.В., Марютина О.О., Степанова А.С., 2004)-аар 46 бодомж бүхий асуулт, нийт 50 асуултыг 25 минут анкет бөглүүлэв.


1. Өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар: Өөрийн сэтгэл хөдлөл мэдрэмжийг таних, түүний үүсэх шалтгааныг ойлгох, амаар дүрслэн илэрхийлэх чадвар






Судалгаанд 16-34 насны 761 оюутан хамрагдсан бөгөөд дундаж нас  $19,79 \pm 0,08$  (95%-ийн илтгэх интервал 19,63-19,95 хооронд), 17-оос доош насны 13(1.71%), 18-19 насны 451(59.34%), 20-21 насны 183(24.08%), 22-23 нас 68(8.95%), 24-25 нас 24(3.16%), 26-аас дээш нас 21(2.76%) байна. Эрэгтэй 108(14,2%), эмэгтэй 653(85,8%) байв. Хот суурин газрын 348(45.79%), аймгийн төвийн 342(45.00%), сумынх 70(9,21%) оюутан хамрагдсан байна. Судалгаанд Улаанбаатар хотын 315(41%), Дархан -Уул хотын 27(3.55%), Эрдэнэт хотын 22(2.89%) нийт хотын 364(47.44%), орон нутгийн 397(52,16%) түүнээс аймгийн төвийн 337(44.2%), сумын төвийн 72(9.46%) байв.

Бусдын сэтгэл хөдлөл, мэдрэмжийг ойлгох чадвар буюу эмпати чадвар нь дундаж оноо  $21.98 \pm 0.16$ , стандарт хазайлт 4.43 байв. Хамгийн бага оноо нь 6 бол их оноо нь 34 байв. Бусдын сэтгэл хөдлөлийг удирдах чадварын дундаж оноо  $14.8 \pm 0.11$ , стандарт хазайлт 3.1 байв. Хамгийн бага оноо нь 4 байсан бол их оноо нь 25 байв. Хүмүүс хоорондын сэтгэл хөдлөлийг ойлгож, удирдах чадварын дундаж оноо  $37.05 \pm 0.24$ , стандарт хазайлт 6.75 байв. Хамгийн бага оноо нь 15, их оноо нь 63 байв. (Зураг 3)




Зураг 3. Эмпатигийн дэд үзүүлэлтүүдийн дундаж, их, бага утга

Бусдын сэтгэл хөдлөл, мэдрэмжийг ойлгох буюу эмпати чадварын маш бага түвшинд 28.91% (n=220), бага түвшинд 26.28% (n=200), дундаж түвшинд 30.75% (n=234), өндөр түвшинд 11.3% (n=86), маш өндөр түвшинд 2.76% (n=21) байв. Бусдын сэтгэл хөдлөлийг удирдах чадварын маш бага түвшинд 45.99% (n=350), бага түвшинд 36.53% (n=278), дундаж түвшинд 14.19% (n=108), өндөр түвшинд 3.02% (n=23), маш өндөр түвшинд 0.26% (n=2) байв. Хүмүүс хоорондын сэтгэл хөдлөлийг ойлгож, удирдах чадварын маш бага түвшинд 36.4% (n=277), бага түвшинд 32.85% (n=250), дундаж түвшинд 21.68% (n=165), өндөр түвшинд 6.83% (n=52), маш өндөр түвшинд 2.23% (n=17) байв. (Зураг 5)



Зураг 4. Эмпатигийн дэд үзүүлэлтүүдийн түвшин

Судалгаанд оролцогчдын 39.29% (n=299) нь стрессгүй, 60.71% (n=462) нь стрессстэй байв. Эмпатигийн бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадварын түвшин нь стрессийн төрөлд (Pearson  $\chi^2 = 17.1820$ ; Pr = 0.002) 17 дахин, хүмүүс хоорондын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, удирдах чадварын түвшин нь стрессийн оноо тус бүрт (Pearson  $\chi^2 = 247.6185$  Pr = 0.000) 247 дахин, стрессийн төрлөөр (Pearson  $\chi^2 = 102.3129$  Pr = 0.000) 102 дахин ялгаатай болох нь статистик ач холбогдолтой байв. (Зураг 5)



**Зураг 5. Эмпатигийн дэд үзүүлэлтүүдийн түвшин стрессийн төрлөөр**

**Хүснэгт 1. Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадварын нэг хүчин зүйлийн T тест**

Variable	obs	Mean	Std.Err	Std.Dev	95% Conf. Interval	
Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар	761	21.95	0.16	4.43	21.64	22.27
mean = mean				t = -18.9181		
H0: mean = 25				Degrees of freedom = 760		
Ha: mean < 25		Ha: mean != 25		Ha: mean > 25		
Pr(T < t) = 0.0000		Pr( T  >  t ) = 0.0000		Pr(T > t) = 1.0000		

Дундаж утгын хувьд алтернатив таамаглалыг баталгаажуулж байна.

**Хүснэгт 2. Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадварын нэг хүчин зүйлийн T тест**

Variable	obs	Mean	Std.Err	Std.Dev	95% Conf. Interval	
Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадвар	761	14.80	0.11	3.18	14.57	15.02
mean = mean				t = -36.3930		
H0: mean = 19				Degrees of freedom = 760		
Ha: mean < 19		Ha: mean != 19		Ha: mean > 19		
Pr(T < t) = 0.0000		Pr( T  >  t ) = 0.0000		Pr(T > t) = 1.0000		

Дундаж утгын хувьд алтернатив таамаглалыг баталгаажуулж байна.

**Хүснэгт 3. Хүмүүс хоорондын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, удирдах чадварын нэг хүчин зүйлийн T тест**

Variable	Obs	Mean	Std.Err	Std.Dev	95% Conf. Interval	
Хүмүүс хоорондын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, удирдах чадвар	761	37.05	0.24	6.75	36.57	37.53
mean = mean				t = -24.2717		

H0: mean = 43		Degrees of freedom = 760	
Ha: mean < 43	Ha: mean != 43	Ha: mean > 43	
Pr(T < t) = 0.0000	Pr( T  >  t ) = 0.0000	Pr(T > t) = 1.0000	


Дундаж утгын хувьд алтернатив таамаглалыг баталгаажуулж байна.

**Хүснэгт 4. Эмпатигийн дэд үзүүлэлтүүдийн Пирсоны корреляцийн коэффициент**


	Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар	Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадвар	Хүмүүс хоорондын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, удирдах чадвар	Өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар
Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар	1.00*** 0.000			
Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадвар	0.44** 0.000	1.00*** 0.000		
Хүмүүс хоорондын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, удирдах чадвар	0.19* 0.000	0.40** 0.000	1.00*** 0.000	
Өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар	0.812*** 0.000	0.548** 0.000	0.615** 0.000	1.00*** 0.000
Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны коэффициент	0.650** 0.000	0.726*** 0.000	0.824*** 0.000	0.878*** 0.000

Тайлбар: \*Сул хамааралтай, \*\*Дундаж хамааралтай, \*\*\*Хүчтэй хамааралтай.

Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар болон стрессийн оноо хоорондоо ( $r = 0.001$ ,  $p=0.01$ ) бол хувьсагчид шугаман хамааралгүй. Гэсэн хэдий ч хоёр хувьсагчдын хооронд шугаман бус хамаарал байж болно гэж үзэв. (Зураг 6) Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадвар болон стрессийн оноо хоорондоо ( $r = -0.245$ ,  $p=0.000$ ) урвуу сул хамааралтай байв. (Зураг 7)




Зураг 6. Стрессийн оноо болон бусдыг ойлгох чадвар




Зураг 7. Стрессийн оноо болон бусдын сэтгэл хөдлөл мэдрэмжийг удирдах чадвар

Хүмүүс хоорондын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, удирдах чадвар болон стрессийн оноо хоорондоо ( $r = -0.421, p=0.000$ ) урвуу дундаж хамааралтай байв. (Зураг 8) Өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар болон стрессийн оноо хоорондоо ( $r = -0,191, p=0.000$ ) урвуу сул хамааралтай байв. (Зураг 9)



Зураг 8. Стрессийн оноо болон хүмүүс хоорондын сэтгэл хөдлөлийг ойлгож, удирдах чадвар



Зураг 9. Өөрийн сэтгэл хөдлөл мэдрэмжийг ойлгох чадвар

**Хүснэгт 5. Эмпатигийн дэд үзүүлэлтүүдийн стресс нөлөөллийн нийлмэл шугаман регресс**

srq_score	Coefficient	Std. err.	t	P> t	[95% conf. interval]	
Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар	0.174	0.04	3.75	0.000	0.08	0.26
Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадвар	-0.276	0.06	-3.96	0.000	-0.41	-0.13
Хүмүүс хоорондын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, удирдах чадвар	-0.316	0.03	-10.54	0.000	-0.37	-0.25
<b>_cons</b>	21.42	1.28	16.61	0.000	18.88	23.95

Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадварын оноо нэгээр нэмэгдэхэд стрессийн оноо 17.4%-аар нэмэгдэж байна. Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадварын оноо нэгээр нэмэгдэхэд стрессийн оноо 27.6%-аар буурч байна. Хүмүүс хоорондын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, удирдах чадварын оноо нэгээр нэмэгдэхэд стрессийн оноо 31.6%-аар буурс байна.

**Хэлэлцүүлэг**

Судалгаануудын үр дүнгүүдийг харьцуулахад 3-4-р дамжаанд эмпати чадвар буурч байгааг олон эрдэмтэд нотолж байгаа боловч бидний хийсэн судалгааны үр дүнд дамжааны ялгаа ажиглагдсангүй. 2020-2025 онд хийгдсэн судалгааны дундаж үзүүлэлтээс доогуур байна. Судлаачдын хэрэглэсэн эмпатигийн түвшин тодорхойлсон арга зүй нь өөр өөр учир 100 оноотой дүйцүүлэн харьцуулахад 2021 онд хийсэн 15 улсын метаанализ судалгаанд дундаж оноо 70 орчим, тус оны Словени улсын анагаахын оюутнуудын дунд хийсэн судалгаанд 77, 2022 онд Канадын анагаахын оюутнуудын дундаж 76±2, 2023 онд БНХАУ-ын эрүүл мэндийн чиглэлийн оюутнуудын дундаж 70±2, 2024 онд Австрали улсын анагаахын оюутнуудын дундаж 77.5±2.5, 2023 оны Энхзул & Эрдэнэцэцэг нарын сувилахуйн оюутнуудын дундаж 64.5±1.5, тус онд судалгааны материал цуглуулсан бидний судалгаанд 64.64±0.47, 2024 оны

Идэрбат нарын хийсэн эрүүл мэндийн чиглэлийн оюутнуудын дундаж  $69 \pm 1$  байгаа нь дэлхийн дунджаас 5-10 оноогоор бага байгаа боловч суралцах идэвх өндөр, жил ирэх тусам дундаж оноо өсөж байна.

### Дүгнэлт

1. РМС их өгөгдлийн сангаас түлхүүр үгээр хайлт хийж Библиометрийн задлан шинжилгээний үр дүнд эмпати чадварыг цаг хугацааны 5 кластераар сувилахуй, эм зүй, анагаах зэрэг эрүүл мэндийн салбарын оюутан сургалтын хөтөлбөр, эмч, өвчтөн, багш оюутны хоорондын харилцаатай холбон судалгаа хийж байна.
2. Этүгэн их сургуулийн харьяа Эрүүл мэндийн сургуулийн оюутнуудын эмпати чадвар дунджаас доогуур байна. Нас, хүйс, дамжаагаар ялгаагүй байв. Эмпатигийн бусдыг ойлгох, мэдрэх чадвар нэмэгдэх нь стресс үүсэхэд нөлөөлж байна. Харин бусдын сэтгэл хөдлөл мэдрэмжийг ойлгож, удирдах чадвар нь стрессийн оноотой урвуу дундаж хамааралтай байхаас гадна энэхүү чадвар нэмэгдэх нь стрессийг даван туулах, стресст өртөхгүй байхад нөлөөлж байна.

### Ашигласан материалын жагсаалт

- Boshra, M., Lee, A., Kim, I., Malek-Adamian, E., Yau, M., & LaDonna, K. A. (2022). When patients teach students empathy: A systematic review of interventions for promoting medical student empathy. *Canadian Medical Education Journal*, 13(6), 46–56. <https://doi.org/10.36834/cmej.73058>
- Cairns, P., Isham, A. E., & Zachariae, R. (2024). The association between empathy and burnout in medical students: A systematic review and meta-analysis. *BMC Medical Education*, 24(1), 640. <https://doi.org/10.1186/s12909-024-05625-6>
- Chen, A. M. H., Blakely, M. L., Daugherty, K. K., Kiersma, M. E., Meny, L. M., & Pereira, R. (2024). Meaningful connections: Exploring the relationship between empathy and professional identity formation. *American Journal of Pharmaceutical Education*, 88(8), 100725. <https://doi.org/10.1016/j.ajpe.2024.100725>
- Chmielewski, J., Łoś, K., & Łuczynski, W. (2021). Mindfulness in healthcare professionals and medical education. *International Journal of Occupational Medicine and Environmental Health*, 34(1), 1–14. <https://doi.org/10.13075/ijomeh.1896.01542>
- Evans, W., Lisiecka, D., & Farrell, D. (2023). Exploring the impact educational interventions have on nursing and medical students' attitudes and empathy levels towards people with disability: A systematic review. *Journal of Intellectual Disabilities*. <https://doi.org/10.1177/17446295231155781>
- Gilligan, C., Powell, M., Lynagh, M. C., Ward, B. M., Lonsdale, C., Harvey, P., James, E. L., Rich, D., Dewi, S. P., Nepal, S., Croft, H. A., & Silverman, J. (2021). Interventions for improving medical students' interpersonal communication in medical consultations. *Cochrane Database of Systematic Reviews*, 2(2), CD012418. <https://doi.org/10.1002/14651858.CD012418.pub2>
- Howick, J., Dudko, M., Feng, S. N., Ahmed, A. A., Alluri, N., Nockels, K., Winter, R., & Holland, R. (2023). Why might medical student empathy change throughout medical school? A systematic review and thematic synthesis of qualitative studies. *BMC Medical Education*, 23(1), 270. <https://doi.org/10.1186/s12909-023-04165-9>

- Kampourelli, V. (2022). Historical empathy and medicine: Pathography and empathy in Sophocles' *Philoctetes*. *Medicine, Health Care and Philosophy*, 25(3), 561–575. <https://doi.org/10.1007/s11019-022-10087-y>
- Levett-Jones, T., Brogan, E., Debono, D., Goodhew, M., Govind, N., Pich, J., River, J., Smith, J., Sheppard-Law, S., & Cant, R. (2024). Use and effectiveness of the arts for enhancing healthcare students' empathy skills: A mixed methods systematic review. *Nurse Education Today*, 138, 106185. <https://doi.org/10.1016/j.nedt.2024.106185>
- Menezes, P., Guraya, S. Y., & Guraya, S. S. (2021). A systematic review of educational interventions and their impact on empathy and compassion of undergraduate medical students. *Frontiers in Medicine*, 8, 758377. <https://doi.org/10.3389/fmed.2021.758377>
- Pub Med Central. (2025). User Guide. <https://pmc.ncbi.nlm.nih.gov/about/userguide/>
- Tement, S., Ketiš, Ž. K., Mirošević, Š., & Selič-Zupančič, P. (2021). The impact of psychological interventions with elements of mindfulness (PIM) on empathy, well-being, and reduction of burnout in physicians: A systematic review. *International Journal of Environmental Research and Public Health*, 18(21), 11181. <https://doi.org/10.3390/ijerph182111181>
- Zhang, X., Pang, H. F., & Duan, Z. (2023). Educational efficacy of medical humanities in empathy of medical students and healthcare professionals: A systematic review and meta-analysis. *BMC Medical Education*, 23(1), 925. <https://doi.org/10.1186/s12909-023-04932-8>
- Zhou, Y. C., Tan, S. R., Tan, C. G. H., Ng, M. S. P., Lim, K. H., Tan, L. H. E., Ong, Y. T., Cheong, C. W. S., Chin, A. M. C., Chiam, M., Chia, E. W. Y., Lim, C., Wijaya, L., Chowdhury, A. R., Kwek, J. W., Fong, W., Somasundaram, N., Ong, E. K., Mason, S., & Krishna, L. K. R. (2021). A systematic scoping review of approaches to teaching and assessing empathy in medicine. *BMC Medical Education*, 21(1), 292. <https://doi.org/10.1186/s12909-021-02697-6>
- Баттоого, Б., Гэндэнжамц, С., Болдсүрэн, Б., Зүчи, Л. (2024). Эмпати чаварыг тодорхойлох асуулгын психометрик чанарыг судалсан нь. Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл, 29(2). DOI:<https://doi.org/10.56380/mjer.v29.2.2>
- Баатарсүрэн, Б. (2024). Эмпати чадварыг тодорхойлох асуулгын психометрик чанарыг судалсан.
- Люсин, Д. В., Марютина, О. О., & Степанова, А. С. (2004). Структура эмоционального интеллекта и связь его компонентов с индивидуальными особенностями: эмпирический анализ. С 69 *Социальный интеллект: Теория, измерение, исследования/Под ред. ДВ Люсина, ДВ Ушакова.—М.: Изд во «Институт психологии РАН», 2004.—176 с.(Труды Института психологии РАН)*, 129.
- Дөлгөөн, А. (2021). “Эмпати хэмжих Брайнтын асуулга”-ын баталгаат, тохирох нөөц судалсан нь. *Сэтгэл судлалын бакалаврын судалгааны ажил*. Улаанбаатар
- Идэрбат, А., Хажидмаа, О., Бишхорлоо, Б., & Лхамсүрэн, З. (2024). Өөртөө энэрэнгүй хяналт хэмжих асуулгын психометрик нөөц судалсан нь. *Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл*, 29(1). <https://doi.org/10.56380/mjer.v29.1.1>
- Энхзул, Г., & Эрдэнэцэцэг, М. (2023). Зарим оюутнуудын эмпати чадварын түвшин. Оюунлаг оюутан 2023, *Сувिलाхуйн оюутны эрдэм шинжилгээний салбар хурал*, 62–63.